ВИДЕО ШТОРК · 2024 оны 10-р сарын 17

2024 ОНЫ III УЛИРАЛ - ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРЭГ БУУРСАН БАЙНА



Прокурорын байгууллагаас 2024 оны III улиралд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодох, харгис хэрцгий харьцах зэргээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 863 хэрэгт хяналт тавьсан нь өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар буурсан байна.

Энэ төрлийн гэмт хэрэгт нийт 364 хүнийг эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 240 хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн дийлэнх нь 31-44 насныхан байна. Тодруулбал, энэ төрлийн хэрэгт шалгагдсан 364 хүний 1.4 хувь нь 18 хүртэлх, 17.6 хувь нь 18-30, 23.9 хувь нь 45-аас дээш, 58.2 хувь нь 31-44 насныхан байгаа бол 41.4 хувь нь согтуугаар энэ гэмт хэргийг үйлджээ.

Хүйсийн хувьд 94 хувь нь эрэгтэй, 56.6 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй иргэд байна.

2024 он гарснаас хойш гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 526 гэмт хэрэг шинээр бүртгэгдэн шалгагдсан бөгөөд Нийслэлд 47.1 хувь нь, орон нутагт 52.9 хувь нь бүртгэгджээ.

Видео: https://www.youtube.com/watch?v=khzJ1oHnj2c

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/959